



БҮРЭН
ФИНАНС

Банк бус санхүүгийн байгууллага

“БҮРЭНФИНАНС ББСБ” ХХК

2025

БҮТЭХ ҮЙЛСИЙН БАТ ГҮҮР



БҮРЭН
ФИНАНС
Банк бус санхүүгийн байгууллага

■ **БИДНИЙ ТУХАЙ**


■ **АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО**

■ **САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

■ **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД**

■ **ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛД ХИЙГДСЭН АЖЛУУД**

■ **НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД**



БИДНИЙ ТУХАЙ



“Бүрэнфинанс ББСБ” ХХК нь 2013.11.01-ний өдөр Зээлийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан түүхтэй.

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-оос авсан Банк бус санхүүгийн тусгай болон энгийн зөвшөөрлүүд:

- ☐ 2014 онд “зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”;
- ☐ 2021 онд “Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”
- ☐ 2024 онд “Факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”;
- ☐ 2024 онд “Төлбөрийн баталгаа гаргах зөвшөөрөл”
- ☐ 2024 онд “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл”.

Жил бүр үйл ажиллагаагаа өргөжүүлэн, Улаанбаатар хотод 8 салбар нэгжтэй, компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад хүргэж байна.

Компанийн алсын хараа

Монголын санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь болон үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэн олон талт үйл ажиллагаатай тэргүүлэгч ББСБ, харилцагч үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн түнш нь байх

Эрхэм зорилго

Харилцагчдын эрэлтэд нийцсэн чанартай, шуурхай санхүүгийн үйлчилгээг тогтмол, найдвартай хүргэх төдийгүй үргэлж өсөлт, дэвшилд тэмүүлэх




Санхүүгийн үзүүлэлт




- ❖ Өсөлтийн стратегийн хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж 5.0 тэрбум төгрөгт хүргэсэн.
- ❖ 2025 оны 1-р улирлын байдлаар нийт актив 39.8 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 12.8 тэрбум төгрөгт хүрээд байна.
- ❖ 2025 оны 1-р улирлын байдлаар 0.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ашиглалаа.


Нийт актив /Тэрбум төгрөг/



Өөрийн хөрөнгө /Тэрбум төгрөг/



Цэвэр ашиг /Тэрбум төгрөг



Цэвэр ашгийн өсөлт

106%

Жилийн дундаж өсөлт

66.6%

Санхүүгийн үзүүлэлт



Бид хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай нээлттэй, ил тод, харилцан ашигтай хамтран ажиллахад анхаарч ажилладаг.

Бүрэн Бонд-1

“Бүрэн Бонд-1 хөтөлбөр”-ийн 1-р транчийн 1.5 тэрбум төгрөгийн бондын төлөлтийг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Бүрэн Бонд-2

Бүрэн Бонд-2 хөтөлбөр”-ийн хүрээнд 4.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийг биржийн бус зах зээл дээр гаргах зөвшөөрлийг МҮЦАЭХ-с авч, 1.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд



Management Forum 2025

“Бүрэнфинанс ББСБ” ХХК нь сайн сайхныг нийгэмд бүтээх зорилгоор “Менежментийн Форум 2025” арга хэмжээний ивээн тэтгэгч, зохион байгуулагчаар оролцов. Үүний хүрээнд:

- бизнес эрхлэгчидтэй туршлага, мэдлэгээ хуваалцаж;
- компанийн бүтээн байгуулалтыг нийгэмд таниулав.

Buren Networking Night 2025

Компанийн зорилтод харилцагчидад зориулан "Buren Networking Night" арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд:

- хамтран ажилладаг “Автомашины дилер”-ийн худалдаа эрхлэгч 45 иргэд, аж ахуйн нэгжүүд оролцов;
- ББСБ-ын үйл ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтийг танилцуулж, мэдээлэл хүргэв;
- ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилж, шинэ бүтээгдэхүүнийг танилцуулж ажиллалаа.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд



Төв оффисын байрыг өртгөтгөн тохижуулав

Компанийн төв оффисыг шинэчлэн, зохион байгуулж, 370 м.кв2 орчин үеийн загвар, дизайны шийдэл бүхий, ажлын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчдад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ ойртуулав

Компани нь харилцагчдад хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, Хан-Уул дүүрэгт "Соёолжмолл салбар"-ыг шинээр байгуулж, үйл ажиллагаагаа өргөжүүллээ.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд



Bitrix24

Компанийн ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, дотоод харилцаа холбоог сайжруулах, харилцагчдад чанартай үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Bitrix24 интранет системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэв.



CRM Marketing

Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, борлуулалтын удирдлагыг хэрэгжүүлэв.



Task management

Ажлын урсгалыг автоматжуулж, хамтын ажиллагааг сайжруулав.



Cloud Content Collaboration

ББСБ-ын цахим баримт бичгийн хадгалалт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжрууллаа.



AI assistant

CoPilot-ийн тусламжтайгаар ажилтнуудын бүтээмж нэмэгдэв.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд



Бид ёс зүйг эрхэмлэн, харилцагчдад найдвартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор нийт ажилтнуудыг “Мэргэжлийн ёс зүй” сэдэвт цуврал сургалтад бүрэн хамрууллаа.

Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээлэл, мэдээллийн систем, дэд бүтцийн нууцлал, бүрэн бүтэн байдал, тасралтгүй ажиллагааг хангаж Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг.

Компанийн зүгээс өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах, харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор цуврал контент бүтээж, олон нийтийн мэдээллийн сувгуудаар түгээж байна.

Харилцагчдад зориулсан мэдээлэл авах сувгийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажлыг тогтмол хийж, 24/7 үйлчилгээг харилцагчдад хүргэж байна.

Эрсдэлийн удирдлагын хүрээнд хийгдсэн ажлууд

“Бүрэн Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн /ТУЗ/ зүгээс компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллалаа. Тухайлбал:


01 ТУЗ-ийн хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Компанийн бүтцийг шинэчлэн, дараах бодлого журмыг батлав. Үүнд:
 - ☐ ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам;
 - ☐ “Дотоод аудитын газар” байгуулж, орон тоог батлав;
 - ☐ “Эрсдэлийн удирдлагын бодлого”;
 - ☐ “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”.

Компанийн Гүйцэтгэх захирлын зүгээс компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх дараах арга хэмжээ авч ажиллалаа. Тухайлбал:

02 Гүйцэтгэх захирлын хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Гүйцэтгэх захирлын дэргэдэх “Эрсдэлийн хороо” байгуулав;
- “Эрсдэлийн удирдлагын газар” байгуулж, орон тоог батлав;
- Зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, Гүйцэтгэх захирлын тогтоосон лимитийн хүрээнд зээлийн судалгаанд эрсдэлийн дүгнэлт гарган, шийдвэр гаргалтад эрсдэлийг тооцож байна.



Эрсдэлийн удирдлагын хүрээнд хийгдсэн ажлууд



03

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд

- Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаа;
- Стандарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мэдээллийн аюулгүй байдлын багц журмыг батлаж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна;

ISO 27001:2022 стандартыг нэвтрүүлснээр

- Харилцагчдын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үр дүнтэй удирдах тогтолцоо бий болж, цаашид байнгын сайжруулах нөхцөлийг бүрдүүллээ.

04

Комплаенсын хяналтыг хэржүүлэх хүрээнд

- “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын шинэчилэн батлав;
- СЗХ-ны ирүүлсэн санамж бичгийн хүрээнд судалгаанд идэвхтэй оролцож, холбогдох мэдээллийг хүргүүлж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд



"Санхүүгийнхээ Бэрс нь Би Өөрөө" цуврал сургалт

2025 онд "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв"-тэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, түр хамгаалах байрны үйлчлүүлэгч эмэгтэйчүүдэд зориулан санхүүгийн боловсролын цуврал сургалтыг эхлүүллээ. Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүд нь санхүүгийн үндсэн мэдлэгтэй болж, санхүүгийн бие даасан байдлаа сайжруулах үр чадвар, мэдлэг эзэмшлээ.

Ажилтнуудын нийгмийн халамжийн хүрээнд

Компанийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хөнгөлөлт, урамшууллыг санал болгон ажилладаг. Тухайлбал давхардсан тоогоор:

- ажилтны хөнгөлөлттэй зээл - 25;
- өртөг үнээр автомашин худалдан авах – 15;
- өртөг үнээр гадаадад аялах эрх олох - 30 ажилтан гэх мэт.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд



Компанийн зүгээс ажилтнуудын эрүүл, аюулгүй, тав тухайтай орчинд ажиллах нөхцөлийг хангах зорилгоор нэг ажилтанд ногдох ажлын байрны талбайн хэмжээг нэмэгдүүлж, орчин үеийн загвар, дизайнтай шинэ оффист үйл ажиллагаагаа явуулж байна.

Оффис, салбар нэгжийг камержуулах, бүх нэгжүүдэд анхны тусламжийн хайрцаг, галын хор байршуулах, дотоодын аялал зохион байгуулах зэрэг ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд чиглэсэн ажил, арга хэмжээг зохион байгууллаа.

Ажилтнуудынхаа эрүүл мэндэд анхаарал хандуулан “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг”-т нийт ажилтнуудыг хамруулах ажлыг зохион байгууллаа.

Салбаруудын байршил

Төв салбар



Хаяг:
Пийс Тауэр оффисын 15
давхарт 1506 тоот

22 салбар



Хаяг:
22 авто худалдааны
цогцолбор,
Автоком төвийн
1-р давхарт 108 тоот

Да хүрээ салбар



Хаяг:
Да хүрээ зах,
Да хүрээ авто центр,
2 давхарт 19 тоот

Ачлал салбар



Хаяг:
БГД, 14-р хороо,
Ачлал Их дэлгүүрийн
3 давхарт В-401 тоот

Гурвалжин салбар



Хаяг:
Гурвалжингийн гүүр,
SB барилгын материалын
төвийн өргөтгөл

Максмолл салбар



Хаяг:
Баруун 4 зам,
Макс молл худалдааны
төвийн
1 давхарт 111 тоот

Хан-Уул салбар



Хаяг:
Хан-Уул, 19-ийн
автобусны буудлын
дэргэд
Рагагон төвийн 3
давхарт 302 тоот

Соёолж Молл салбар



Хаяг:
ХУД, 15-р хороо,
нарны зам,
"Соёолж Молл"
худалдааны төвийн
1 давхарт 115 тоот

Холбоо барих



Утасны дугаар:
7018-7778, 7600-0606



Э-мэйл хаяг:
info@burenfinance.mn



Төв оффис:
УБ хот, ЧД, 3-р хороо, Пийс Тауэр оффисын
15 давхарт 1506 тоот